## Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 2023 оны хагас жилийн малын түүвэрчилсэн тооллогын ажлын тайлан

2023.06.12 Лүн

2023 оны мал тооллогын хийх талаар Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр А/50 дугаар захирамж гарсан ба захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй хагас жилийн түүвэрчилсэн тооллого хийгдсэн байна.

Хагас жилийн мал тооллого эхлэхийн өмнө автомашины техникийн бүрэн бүтэн байдал, хувийн бэлтгэлийг хангаж, тооллогод хамрагдах өрхийн маршрут, отор нүүдлээр явсан өрхийн жагсаалт, холбогдох утас болон бусад бэлтгэл ажлуудыг бүрэн хангаж ажилласан.

Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн н.Мөнхбат, Сумын орлогч дарга Э.Эрхэмбаатар, Лүн, Их уул багийн засаг дарга нарын хамт сумын 5 малчин өрхөөр орж хяналтын тоо хийсэн бөгөөд гарсан зөрчил дутагдал байхгүй болно.

Хагас жилийн түүвэрчилсэн малын тооллогоор Лүн баг 15 малчин, мал бүхий өрх, Их-уул баг 6 малчин, мал бүхий өрх нийт 21 малчин мал бүхий өрх сонгогдон тооллогодсон байна. нийт 21 малчин мал бүхий өрх тооллогод хамрагдснаас 100 хувь хамруулан ажиллаа. Мөн Лүн баг 275 км Их-уул баг 251 км нийт 526 км явж нийт 200.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулан ажилласан байна.

Тус суманд малын хагас жилийн түүвэрчилсэн тооллогоор нийт 21 малчин,мал бүхий өрх хамрагдсан бөгөөд Нийт 11407 таван хошуу мал тоологдсоноос Лүн баг 7358, Их-уул баг 4049 таван хошуу мал тооллогодсон байна. Таван хошуу малыг төрлөөр задалбал:

- Тэмээ - **0**
- Адуу - **327**
- Үхэр - **257**
- Хонь - **6134**
- Ямаа - **4689**

Хагас жилийн түүвэр тооллогын Лүн баг





Хагас жилийн түүвэр тооллогын Их-уул баг





Статистикийн хэлтэс болон Сумын орлогч дарга нар хяналтын тоо





Тооллогоор гарсан хүндрэл бэрхшээлүүд.

Мал тооллогод гарсан шатахууны зардал ЗДТГ-ын тээвэр шатахууны зардалд тусгагддаггүй, өөр суманд нутаглаж байгаа малчдыг тоолоход тооцоолсон шатахууны зардлаас өндөр гарч байсан учраас нилээд хүндрэлтэй байсан. Өөр хүндрэл шалтгаан гараагүй малын хагас жилийн тооллогыг малын программ 100 хувь шивж дууссан байна.

Сумын статистик хариуцсан ажилтан [signature] Л.Отгонпүрэв

1-р баг

| Малын төрөл | Нийт малын тоо | Тухайн өрхийн хувийн малын тоо | Бусдын тавиул малын тоо |
| --- | --- | --- | --- |
| Бүгд | 7358 | 7358 | 0 |
| Адуу | 199 | 199 | 0 |
| Үхэр | 126 | 126 | 0 |
| Хонь | 3732 | 3732 | 0 |
| Ямаа | 3301 | 3301 | 0 |
| **Бүгд** | **7358** | **7358** | **0** |
| **Адуу** | **199** | **199** | **0** |
| **Үхэр** | **126** | **126** | **0** |
| **Хонь** | **3732** | **3732** | **0** |
| **Ямаа** | **3301** | **3301** | **0** |

Х-8 БАГ

| Малын төрөл | Нийт малын тоо | Тухайн өрхийн хувийн малын тоо | Бусдын тавиул малын тоо |
|---|---|---|---|
| Бүгд | 4049 | 4049 | 0 |
| Адуу | 128 | 128 | 0 |
| Үхэр | 131 | 131 | 0 |
| Хонь | 2402 | 2402 | 0 |
| Ямаа | 1388 | 1388 | 0 |
| **Бүгд** | **4049** | **4049** | **0** |
| **Адуу** | **128** | **128** | **0** |
| **Үхэр** | **131** | **131** | **0** |
| **Хонь** | **2402** | **2402** | **0** |
| **Ямаа** | **1388** | **1388** | **0** |